



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар A/30

Улаанбаатар хот

Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 03 дугаар тогтоол, 2020 оны “Зөвшөөрөл олгох тухай” 86 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” А/241 дүгээр захирамж, Газрын дүрмийн 2.5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албаны зөвлөлөөс олгон зөвшөөрлийн дагуу тус газрын Орлогч даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Захиргааны хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Жуулчны аюулгүй байдал, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистик, сургалт, судалгаа хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 10 дугаар, Соёлын аялал жуулчлал, эвент арга хэмжээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 11 дүгээр, Дотоодын аялал жуулчлал, бүтээгдэхүүний хөгжил хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 12 дугаар, Хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 13 дугаар, Маркетинг, сурталчилгаа хариуцсан мэргэжилтний

албан тушаалын тодорхойлолтыг 14 дүгээр, Олон нийтийн харилцаа хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 15 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2015 оны А/15 тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Албан тушаалын тодорхойлолтыг мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

ДАРГА



С.БАТБААТАР